



ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Улс төрийн үйл ажиллагаа
2. Намын хурал, дотоод сонгууль, ил тод байдал
3. Гишүүдийн хөгжил
4. Гадаад харилцаа

2022 ОНЫ ГОЛ ҮЙЛ ЯВДАЛ: 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 19 тоот тогтоолоор Иргэдийн Оролцооны Нэгдэл Намыг улсын бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгох шийдвэр гаргав.

Нэг. Улс төрийн үйл ажиллагаа.

ИОНН 2022 онд парламентын гадна үйл ажиллагаа явуулж буй шинэхэн сөрөг хүчний үүрэгтэйгээр улс төрийн үйл ажиллагаа явуулж 2022 оны 12 дугаар сард болсон Нүүрсний хулгайн эсрэг иргэдийн жагсаал цуглааныг дэмжиж ажиллалаа.

Нүүрсний хулгайн эсрэг 2022 оны 12 сарын 4-нд эхэлсэн иргэдийн жагсаалтын ИОННам дэмжиж, 12 сарын 5 болон 12 сарын 16-ны өдөрт тус тус Засгийн газарт шаардлага хүргүүлж мэдэгдэл гаргасан ба хэвлэлийн хурал зохион байгуулж “хуультай хулгайг” таслан зогсоохыг шаардав.

Хоёр. Намын хурал, дотоод сонгууль, ил тод байдал

- Намын үүсгэн байгуулах хурал 2022 оны 3 сарын 3-ны өдөр хуралдав. Энэ нь 2021 оны 9 сарын 9-нд болсон үүсгэн байгуулах хурлын шийдвэрийг Улсын Дээд Шүүх бүртгэхээс татгалзсантай холбоотойгоор хоёр дахь удаагаа хуралдсан хурал байв.
- ИОНН-ын 2022 оны 3-р сарын 3-нд болсон дотоод сонгуулиар Төлөөлөгчдийн Танхим, Үнэт зүйлийн зөвлөл, Маргаан таслах комисст нэрээ дэвшүүлсэн гишүүдийг сонгож баталлаа.
- Намын үүсгэн байгуулах хурлаар Иргэдийн Оролцооны Нэгдэл намын дүрэм, намын мөрийн хөтөлбөрийг батлав.
- Төлөөлөгчдийн Танхим 3 удаа хуралдсан ба дараах журам, зааврыг батлав. Үүнд:
 - ТТ-ын 2022 оны 2-р хурлаас “Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын дүрэм хэрэгжүүлэх заавар”-ыг батлав.
 - ТТ-ын 2022 оны 2-р хурлаас “ИОНН-ын Маргаан таслах комиссын ажиллах журам”-ыг батлав.
- Үнэт зүйлийн зөвлөл хоёр удаа хуралдаж тус бүрт улс төрийн мэдэгдэл гаргаж УИХ-ын дарга, Засгийн Газрын тэргүүнд хүргүүлжээ.
- Намын өдөр тутмын болон улс төрийн үйл ажиллагааг цахим орчинд дараах хаягаар мэдээлж ажиллав. Үүнд:
 - www.cup.mn
 - <https://www.facebook.com/civicunitypartyMN>
 - <https://www.instagram.com/civicunitypartymn/>

- <https://twitter.com/civicunityparty>
- Намын гишүүдэд “Иргэний оролцоо” апп-аар дамжуулан зарыг хүргэж ирэв.

Гурав. Гишүүдийн хөгжил

- 2022 онд Намын гишүүдийн хөгжилд зориулж 9-12-р сарын долоо хоног бүрийн Пүрэв гаригт сургалт зохион байгуулж ирлээ. Нийт 16 сургалтыг нээлттэй зохион байгууллаа.
- Гишүүдийн шинэ жилийн арга хэмжээг гишүүдийн оролцоотойгоор 2022 оны 12 сарын 19-ны өдөр үнэ төлбөргүй зохион байгуулав.

Дөрөв. Гадаад харилцаа

- Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын удирдлага 2022 оны Германы Конрад Аденауэрийн Сангийн Монгол дах төлөөлөгчийн газар, АНУ-ын Бүгд Найрамдахчуудын хүрээлэнгийн Монгол дах төлөөлөгчийн газар болон Вашингтон хот дахь төвийн албаны хүмүүстэй уулзаж, намын танилцуулгыг хийв.